



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 11 сарын 15 өдөр

Дугаар Б/87

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Төрийн албаны тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт, Албаны дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны мэргэжилтэн Цогтсайхан овогтой Нямсүрэн нь удаа дараа /2 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн тул үүрэгт ажлаас нь 2013 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, холбогдох тооцоог хийж дуусгахыг комиссын дарга /Ч.Цог/-д даалгасугай.

Ажил хүлээлцэх комиссын бүрэлдэхүүн: Дарга: Ч.Цог /ЗУХДарга/

Гишүүд: О.Алтангэрэл /Мэргэжилтэн/

Д.Санчирбаяр /Мэргэжилтэн/

П.Ариунаа /Нягтлан бодогч/

Г.Цэрэннадмид /Нярав/

3. Энэхүү тушаал гарч мөрдөгдөх болсонтой холбогдуулан 2013 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн Б/15 тоот тушаалын хоёрдугаар хавсралтын холбогдох заалтыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН